



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлд хэрэгжсэн авто замын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцтай холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/27-ШТА-ГА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-т зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Замын Хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010303



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь нэмэлт санхүүжилт шаардагдах, ТАХ удаашрах үндэслэл болжээ.



АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛД ХЭРЭГЖСЭН АВТО ЗАМЫН ГҮҮР, ГҮҮРЭН БАЙГУУЛАМЖ, НҮХЭН ГАРЦТАЙ ХОЛБООТОЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Улаанбаатар хот
2024 он

Хэлтсийн дарга
Э.Мөнхмандах

Аудитын менежер:

Б.Номинбаатар

Ахлах аудитор:

Г.Чулуунцэцэг

Аудитор:

Ч.Чулуун-Эрдэнэ

Товчилсон үг	2
Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт	3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 4

Бүлэг 1. А. Авто замын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцын төсөл, арга хэмжээний төлөвлөлт оновчтой байна уу? 5

А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу? 5

А.2. Төсөл, арга хэмжээг Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөсөн үү? 6

А.3. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцсон уу? 6

А.4. Төсөл, арга хэмжээ нь төсөвлөлтийн болон холбогдох стандартын шаардлагын дагуу төлөвлөсөн үү? 8

Б. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу? 10

Б.1. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан уу? 10

Б.2. Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулсан уу? 12

Б.3 Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан эсэх, гэрээ нь хуульд нийцсэн үү? 12

Б.4. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу? 13

Б.5. Төсвийн хөрөнгөөр оруулалтаар хэрэгжсэн гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцын хөрөнгийг бүртгэлжүүлж, ашиглалт, хамгаалалтыг эзэнжүүлсэн үү? 15

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787

Тайланг НТАГ-ын <http://audit.mn/> веб сайтаас үзнэ үү.

Аудитын дүгнэлт	17
Аудитын зөвлөмж	18
Холбогдох байгууллагын санал	19

Товчилсон үг	
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ГЗХ	Гадаадын зээлийн хөрөнгө
ДТХО	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг Дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХУТ	Замын хөдөлгөөний удирдлагын төв
ЗТХ	Зам, тээвэр хөгжил
ИТА	Инженер, техникийн ажилтан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол Улс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НТХО	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
НУХАЗТБНТХН	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУ	Олон улс
СБД	Сүхбаатар дүүрэг
ТЦА	Тээврийн цагдаагийн алба
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
УБЗЗАГ	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар
УИХ	Улсын Их Хурал
ХУД	Хан-Уул дүүрэг
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Нийслэлд 2016-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ	5
Хүснэгт 2	ТАХ-ний үр дүнг зарим байршлууд дээр харьцуулсан байдал	7
Хүснэгт 3	ХАА зохион байгуулж гүйцэтгэгч сонгон шалгарсан ТАХ	10-11
Хүснэгт 4	Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан ТАХ	13
Хүснэгт 5	Архивын нэгж үүсгээгүй ТАХ-ний жагсаалт	15
Хүснэгт 6	Бүртгэлд тусгаагүй ТАХ	15-16

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Замын Цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл.	14
Дүрслэл 2	Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, гүүрний барилга	14
Дүрслэл 3	Наадамчдын гудамж, Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих ажил	14
Дүрслэл 4	Тахилтын авто замаас Авто цогцолбор хүртэлх 1.5 км авто зам, төмөр зам доогуур нүхэн гарцын хамт /СХД/	14

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.
Аудитын зорилт	Нийслэлд хэрэгжсэн авто замын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцтай холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд:  Авто замын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцын төсөл, арга хэмжээний төлөвлөлт оновчтой байсан эсэх;  Төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад НЗДТГ, НХААГ, НЗХГ, НХОГ ОНӨААТҮГ, НӨХГ, дүүргүүдийн ЗДТГ, холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817:2020, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Чулуунцэцэг, аудитор Ч.Чулуун-Эрдэнэ нар гүйцэтгэв.

А. АВТО ЗАМЫН ГҮҮР, ГҮҮРЭН БАЙГУУЛАМЖ, НҮХЭН ГАРЦЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ОНОВЧТОЙ БАЙНА УУ?

Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор 2016-2023 онд нийт 489,608.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ, ""Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоол, "МУЗГ-ын 2015 оны 309, 458 дугаар тогтоол"-оор 132.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 5 ТАХ, БНХАУ-ын ЗГ-аас Монгол Улсын Засгийн газарт олгох "Нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг ашиглах тухай" зээлийн ерөнхий хэлэлцээр, МУЗГ-ын 2018 оны 160 дугаар тогтоолоор 40.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1 ТАХ, гадаадын зээл тусламжаар 3,153.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ. Тус ТАХ-үүдээс 87.2% буюу 281,700.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ТАХ, гадаадын зээлийн хөрөнгөөр 172.8 сая ам долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ, 3,153.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, нийт 34 ТАХ-г хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, 207,908.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ нь МУЗГ, ИТХ-ын тогтоол болон ЗД-ын захирамжаар хүчингүй болсон буюу хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1/

А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?

УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" урт хугацааны бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлж байсан бол 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050" хөгжлийн бодлогын баримт бичгийг 9 зорилго, 47 зорилт, 73 шалгуур үзүүлэлтээр 3 үе шатанд /I үе шат 2021-2030 он, II үе шат 2031-2040 он, III үе шат 2041-2050 он/ хэрэгжүүлэхээр баталжээ.

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 он, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Дүүргийн Засаг даргын 2016-2020 он, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-үүдэд үндэслэн нийслэлд хэрэгжүүлэх ТАХ-үүдийг баталжээ.

Хүснэгт №1. Нийслэлд 2016-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ

/сая төгрөг/

Дотоодын эх үүсвэр		Гадаадын зээл тусламж			
Тоо	Төсөвт өртөг /Төгрөг/	Тоо	Төсөвт өртөг /ам.доллар/	Тоо	Төсөвт өртөг /Төгрөг/
32	489,608.6	6	172.8	1	3,153.2

Нийслэлд 2016-2023 онд хэрэгжүүлэх ТАХ-үүдийг МУ-ын хөгжлийн бодлогын урт хугацааны баримт бичиг болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлж, нийслэлд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Дүгнэлт: Нийслэлд 2016-2023 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-нүүдийг хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны баримт бичигт уялдуулан төлөвлөсөн байна.

А.2. Төсөл, арга хэмжээг Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөсөн үү?

УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага бодлогын баримт бичгийг баталжээ.

Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 39 ТАХ-ээс 74.4% нь буюу 284,853.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ, гадаадын зээлийн хөрөнгөөр 40.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1 ТАХ-г “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын 3.3.2¹, 3.3.3² заалтуудад нийцүүлэн төлөвлөж, 25.6% нь нийцээгүй байна.

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих 132.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 5 ТАХ-г *“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай* Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоол, *“МУ-ын ЗГ-ын 2015 оны 309, 458 дугаар тогтоол”*-д нийцүүлэн төлөвлөсөн байна.

Дүгнэлт: Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 25.6% нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцээгүй байна.

А.3. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох шалгуур үзүүлэлтээр үнэлж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцсон уу?

ТАХ-үүдийг төлөвлөхдөө холбогдох хуулийн заалтыг баримталсан эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд *“Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих”* 40.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжих 1 ТАХ-нд эдийн засгийн үр өгөөжийн шинжилгээ хийсэн, харин 492,761.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ТАХ, гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжих 132.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 5 ТАХ-нд эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³, 29 дүгээр зүйлийн 29.1⁴ дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6⁵, 5.1.8⁶, 5.1.9⁷, 5.1.11⁸ дэх заалтыг зөрчжээ.

Аудитаар НЗХГ, ЗХУТ, ТЦА-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийхэд 2016-2023 онуудад хэрэгжүүлсэн ТАХ-ний үр нөлөөг тооцоолсон судалгаа байхгүй, хөдөлгөөний эрчмийг тодорхой бүсэд гараар тоолдог, шинээр ашиглалтад орсон гүүр, гүүрэн байгууламжуудад зөвхөн зөрчил илрүүлдэг хяналтын камеруудыг суурилуулсан зэрэг хүндрэл бэрхшээл илэрсэн. Энэ нь эдийн

¹ Хотын үндсэн бүтцийг боловсронгуй болгон, газар ашиглалт, хот төлөвлөлтийн бүсчлэлийн тогтолцоог шинэчлэн, хэрэгжүүлэх

² Гудамж зам, тээврийн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх

³ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁴ 29¹.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

⁵ 5.1.6.нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;

⁶ 5.1.8.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

⁷ 5.1.9.зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;

⁸ 5.1.11.төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;

засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцоолох өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

Тухайн байгууллагууд нь чиг үүргийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

Хүснэгт №2. ТАХ-ний үр дүнг зарим байршлууд дээр харьцуулсан байдал

№	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	СУУРЬ ТҮВШИН	ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨВТ ӨРТӨГ ОГНОО.	ХҮРСЭН ТҮВШИН
ГАДААДЫН ЗЭЭЛ, ТӨСЛӨӨР ХЭРЭГЖСЭН АЖИЛ				
1.	Замын Цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарцын төсөл /БНХАУ/	Замын Цагдаагийн газрын ойролцоох төмөр замын гарамтай нэг түвшин огтлолцсон, гэрлэн дохиогоор зохицуулагддаг, галт тэрэг явах болгонд авто машины хөдөлгөөн өдрийн 5-8 цаг бүрэн зогсож түгжрэл үүсгэдэг.	2016-2022 онд 35,692,956 ам.доллараар олон түвшний уулзвар болгож барьсан.	Төмөр замын гарам дээрх хүлээлтийн хугацаа байхгүй болсон. Хөдөлгөөн зохион байгуулалтын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн болно.
2.	Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл /БНХАУ/	Яармагийн хуучин гүүрний ашиглалтын хугацаа дууссан нэвтрүүлэх чадвар хангахгүй, хөдөлгөөний аюулгүй байдал алдагдсан.	Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл /БНХАУ/ 30,260,333 сая ам.доллар 2016-2022 онд олон түвшний уулзвар болж баригдсан.	Тус гүүр нь Хөшгийн хөндийн ОУ-ын Нисэх буудлын төсөл, болон Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ШИНЭ ЯАРМАГ төвийг бий болгоход гол үр дүнтэй гүйцэтгэсэн. Тухайн гүүрнүүд нь ОУ-ын АН-3 чиглэлийн замын ангиллын үзүүлэлтэд хүрч ажиллах болсон. Мөн хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж ослын тоо багассан.
3.	Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүр барих төсөл /БНХАУ/	ОУ-ын АН-3 чиглэлийн замын нэг хэсэг боловч тухайн замын ангиллын түвшинг хангаж ажиллаж чадахгүйд хүрч хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж, осол аваар ихээр гарах болсон.	Төсөл /БНХАУ/-ийг 2018-2021 онд 18.198.186 сая ам.доллараар хэрэгжүүлсэн.	
ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН АЖИЛ				
1.	Ахмадын хорооллын орчмын Нарны зам, Дүнжингаравын авто замыг холбосон төмөр зам доогуурх явган зорчигч, автомашинд зориулсан нүхэн гарц, авто зам /БЗД/	Дүнжингарав болон Шинэ зуун айл, Наран туул, Өгмөөр зах, төмөр зам гэх мэт олон зах, худалдааны төвүүд дагасан нягтрал, түгжрэл ихээр үүсгэж, явган болон авто машинаар харилцах зорчиход хүндрэлтэй.	2019-2020 онд 3.070.403.498 төгрөгөөр хэрэгжүүлсэн.	Төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр авто машины хөдөлгөөний нягтрал төвлөрөл хуваарилагдаж, Нарантуулын уулзварын нэвтрүүлэх чадвар 30 хувиар нэмэгдсэн.
2.	Зайсангийн төмөр бетон гүүрний өргөтгөл, шинэчлэлт	Ээлжийн болон их засварын ажил хийгдэж байгаагүй, хөдөлгөөний эрчим хангахгүй болсон.	2022-2024 онд 29.715.990.083 төгрөгөөр хэрэгжүүлсэн.	Хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсан.
3.	Наадамчдын гудамж, Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих ажил	Тээврийн хэрэгсэл явган зорчигчийг хөндлөн гаргах хүлээлтийн хугацаа их, явган зорчигчийн аюулгүй байдал алдагдсан.	2022-2023 онд 2.953.762.709 төгрөгөөр хэрэгжүүлсэн.	Авто зам доогуур нүхэн гарц барьснаар авто зам, явган зорчигчийн хөдөлгөөн огтлолцоогүй аюулгүй байдал хангагдаж, авто замын хөдөлгөөний урсгал тасралтгүй болсон.
4.	Алтай хотхон Нарны хорооллын дундах төв авто зам дээгүүрх явган хүний гүүрэн гарц /24, 26 дугаар хороо/	Явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдал алдагдсан.	2023 онд 1.198.150.831 төгрөгөөр хэрэгжүүлсэн.	Явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулсан.

Дээрх арга хэмжээний хэрэгжилтээс үзэхэд тодорхой байршлууд дээр эдийн засаг, нийгмийн үр дүн гарсан харагдаж байгаа хэдий ч техник технологийн дэвшилтэт аргаар илүү нарийвчлалтай, бодитой гаргах боломжийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Төсөл, арга хэмжээ нь үр нөлөөтэй өгч байгаа хэдий ч төлөвлөхдөө эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр дүнг тооцохгүй байна.

А.4. Төсөл, арга хэмжээг төсөвлөлтийн болон холбогдох стандартын шаардлагын дагуу төлөвлөсөн үү?

МУЗГ, Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор 2016-2023 онд нийт 489,608.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ, гадаадын зээлийн хөрөнгөөр 172.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ, 3,153.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ. Тус ТАХ-үүдээс 87.2% буюу 284,853.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ, 172.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ хэрэгжсэн. Харин 12.8% буюу 207,908.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ нь МУЗГ, ИТХ-ын тогтоол болон ЗД-ын захирамжаар хүчингүй болсон буюу хэрэгжээгүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2/

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусган баталж, хэрэгжүүлэхээр заажээ.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 39 ТАХ нь бүгд зураг төсөв шаардлагатай ТАХ-үүд байна. Үүнээс 84.6% буюу 477,809.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ТАХ, 172.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ, нийт 33 ТАХ зураг төсөвтэй, 15.4% буюу 14,952.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ зураг төсөвгүй байна. Тухайлбал:

- “Чингисийн өргөн чөлөөнд КН apartment орчмын авто замд явган хүний гүүрэн гарц /ХУД/”, Төсөвт өртөг: 2,000.0 сая төгрөг, ТАХ нь НЗД-ын 2020 оны А/1252 дугаар захирамжаар хүчингүй болсон. /Батлагдсан зураг төсөвгүй шалтгаанаар төсвийн тодотголоор татагдсан./
- БЗД-т хэрэгжих “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 0.87 км хөлийн голын авто зам, гүүрэн байгууламж”, Төсөвт өртөг: 3,100.0 сая төгрөг, ТАХ нь 2023 онд хэрэгжиж эхлэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан ч ажил нь эхлээгүй.

Харин 165,847.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ, 40.0 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1 ТАХ-нь газрын асуудал шийдвэрлээгүй төлөвлөжээ. Тухайлбал: /Дэлгэрэнгүйг хавсралт 3/

- 7,540.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ нь газар чөлөөлөх ажлаас шалтгаалан төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж дуусаагүй. “Зүүн 4 замын гүүрэн гарцын барилга”, Төсөвт өртөг: 25,000.0 сая төгрөг, ТАХ нь НЗД-ын 2018 оны А/889 дугаар захирамжаар хүчингүй болсон. /Газар чөлөөлөлтийн асуудал шийдвэрлэгдээгүй тул төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэр татагдсан./
- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төсөл”-нь нийслэлд 4 байршилд хэрэгжихээр төлөвлөгдсөн ч 3 байршилд нь газрын асуудал шийдвэрлэгдээгүй шалтгаанаар хэрэгжиж эхлээгүй.

Мөн 48,271.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний хувьд зураг төсөвгүй, олон жилийн өмнө батлагдсан зураг төсөвтэй зэргээс шалтгаалж анх гэрээ байгуулсан үнийн дүн нь хэрэгжилтийн явцад өсжээ. Үүнд:

- “Зайсангийн төмөр бетон гүүрний өргөтгөл, шинэчлэлт” ТАХ нь зураг төсөвгүй байсан шалтгаанаар гэрээний дүн 3,500.0 сая төгрөгөөр;
- “Наадамчдын гудамж, Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих ажил” ТАХ нь зураг төсөвгүй байсан шалтгаанаар гэрээний дүн 1,155.1 сая төгрөгөөр;
- “Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3 у/м төмөр бетон гүүрний барилга” ТАХ нь 2013

оны зурагтай, ЗТХ-ийн сайдын тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох нормд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” журмын 5 дугаар зүйлийн 5.4.13⁹ дахь заалтыг хэрэгжүүлээгүйгээс гэрээний дүн 1,200.0 сая төгрөгөөр тус тус өссөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэснийг зөрчсөн байна.

Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлд барилгын үйл ажиллагааг холбогдох норм, дүрэм, стандартаар зохицуулахаар заасан.

Монгол Улсын авто зам, замын байгууламжийг төлөвлөх, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, засварлах, арчлах үйл ажиллагаа, тэдгээрт хэрэглэгдэх материал, хийц бүтээц, технологи, ашиглалтын үеийн норм, норматив техникийн баримт бичигт авто замын гүүр хоолой, нүхэн байгууламжид дараах гол 5 стандарт, норм дүрмийг баримталдаг байна. Үүнд:

- , Авто зам төсөллөх /ЗЗБНБД 22-004-2016/ - Зам, тээврийн яам /2016/
- , Явган хүний зам талбайн төлөвлөлт, техникийн шаардлага /MNS 6808-2019/ – Стандарт хэмжилзүйн газар /2019/
- , Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS 6056:2009/ - Стандартчилал, хэмжил зүйн газар /2009/
- , Төмөр зам ба авто замын нүхэн байгууламж /БНБД 32-07-10/ - Монгол Улсын зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам /2010 он/
- , Авто замын гүүр ба хоолой төсөллөх /БНБД 32-02-12/ - Зам, тээврийн яам /2013/

Нийслэлд 2016-2023 онд хэрэгжсэн гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцуудыг төлөвлөхдөө олон улсад ашиглаж буй норм норматив, стандарт, техникийн дагуу төлөвлөсөн байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө холбогдох стандартуудад нийцүүлсэн хэдий ч хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

⁹ 5.4.13 Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулснаас хойш 3 жил өнгөрсөн тохиолдолд зураг төсөл, барилгын ажлын төсвийг тухайн үед мөрдөгдөж байгаа норм, журмын дагуу шинэчлэх, баталгаажуулах зардлыг холбогдох нормын дагуу тооцож төсөвт өртөгт тусгана.

Б. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө, гадаадын зээлийн хөрөнгөөр 2016-2023 онуудад шинээр болон шилжин хэрэгжиж буй ТАХ-ний гүйцэтгэлд захиалагч, зохиогч үе шатны хяналтыг цаг тухайд хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч нийт ТАХ-ний 41% нь төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс хэрэгжилт удааширч байна.

Б.1. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан уу?

Нийслэлд 2016-2023 онд 492,761.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ТАХ, 172.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. ТАХ-ний хэрэгжилтийг зохион байгуулах шатанд 207,908.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ хүчингүй болсон. Үүнд:

- Зүүн 4 замын гүүрэн гарцын барилга ТАХ /Газар чөлөөлөлтийн асуудал шийдвэрлэгдээгүй тул төсвийн тодотголоор хасагдсан/
- Сэлбэ сэргэлт төслийн эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажил. /Эх үүсвэр нь нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан бөгөөд үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргах асуудал хойшлогдсонтой холбоотойгоор төсвийн тодотголоор хасагдсан./
- Орбит-Баянголын уулзвараас Найрамдал зуслан хүртэлх 15.3 км авто зам, 24.7 у/м гүүрийн өргөтгөл, шинэчлэлт хийх. /МУЗГ-ын 2016 оны 08 дугаар сарын 17-ны “Концессын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” №37 тогтоолын дагуу тухайн төсөл арга хэмжээг зогсоосон./
- Чингисийн өргөн чөлөөнд КН apartment орчмын авто замд явган хүний гүүрэн гарц /ХУД/. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1252 дугаар захирамжаар хүчингүй болсон. /Батлагдсан зураг төсөвгүй, гэрээ байгуулагдаагүй, төсвийн тодотголоор хасагдсан/
- 1 дүгээр хорооллын арын холбоос авто зам, замын байгууламж. /Худалдан авах ажиллагаа 1 удаа зарлахад оролцогч материал ирүүлээгүй. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу гэрээ байгуулагдаагүй тул нийслэлийн 2022 оны 65 дугаар тогтоолоор төсвийн хөрөнгө татагдаж, хасагдсан/

Концессын гэрээгээр 1,488.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, ЗТХ-ийн сайдын тушаалаар ЭМЯ-нд эрх шилжсэн 2,484.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ хэрэгжсэн.

Бусад ТАХ-ний хувьд НЗД-аас 2016-2023 онд харьяа 5 газарт 248,431.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ, 172.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ, ДТХО-аар 9,755.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-г тус тус худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Хүснэгт №3. ХАА зохион байгуулж гүйцэтгэгч сонгон шалгарсан ТАХ

№	ХАА зохион байгуулсан газар	Тоо	Төсөвт өртөг /Төгрөг/	Тоо	Төсөвт өртөг /Доллар/	/сая төгрөг/ Гэрээний дүн	
						Төгрөг	Доллар
1	ЭМЯ	1	2,484.7	-	-	2,484.7	-
2	НЗДТГ	1	14,961.5	-	-	14,462.7	-
3	НХААГ	12	232,031.4	1	38.2	229,826.1	36.5
4	НЗХГ	5	23,279.7	4	94.6	22,137.7	84.1
5	УБЗЗАГ	1	852.2	-	-	852.2	-
6	НУХАЗТБНТХН	-	0.0	1	40.0	0.0	30.9

7	Концесс /НЗД/	1	1,488.2	-	-	1,488.2	-
8	БГДХААА	1	1,453.2	-	-	1,198.2	-
9	БЗДХААА	1	3,100.0	-	-	2,810.5	-
10	СБДХААА	2	353.4	-	-	349.8	-
11	ХУДХААА	1	3,155.1	-	-	2,953.8	-
12	ЧДХААА	2	1,693.4	-	-	1,547.1	-
Нийт		28	284,852.8	6	172.8	280,111.0	151.5

Дээрх ТАХ-үүдийн ХАА-г зохион байгуулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 199,640.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ, шууд гэрээний аргаар 85,212.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ, 172.8 сая ам.долларын төсөвт өртөгтэй 6 ТАХ, нийт 34 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Үүнээс худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан эсэхийг тулган баталгаажуулахад 41.2% нь буюу 155,848.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ, 38.2 сая ам.долларын төсөвт өртөгтэй 1 ТАХ-нд зөрчил илэрлээ. Тухайлбал: /Дэлгэрэнгүйг хавсралт 4/

Нээлттэй тендер шалгаруулалтын журам:

НХААГ-аас зохион байгуулсан 141,169.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 ТАХ-ний хувьд:

- “Зайсангийн төмөр бетон гүүрний өргөтгөл, шинэчлэлт 225 у/м-ийн ажил” Гэрээний үнийн дүн: 26,215.9 сая төгрөг, Гүйцэтгэгч ЗМЗ ХХК, /Ажил гүйцэтгэхэд шаардагдах машин механизм нь шалгуур үзүүлэлтэд хүрээгүй/
- “Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто замын гүүрэн байгууламж 748 у/м” Гэрээний үнийн дүн: 84,114.1 сая төгрөг, Гүйцэтгэгч Монгол зам групп ХХК, /Тендерийг 4 удаа зарлахдаа ТШЗ-д өөрчлөлт оруулаагүй/

НЗХГ-аас зохион байгуулсан 9,181.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-ний хувьд:

- “Авто зам, гүүрний ажил /СБД 15, 16-р хороо/” Гэрээний дүн: 3,970.2 сая төгрөг, Гүйцэтгэгч Ди Вай Кэй Би ХХК, /ИТА-ны мэргэжил, ажлын туршлага нь шаардлагад нийцээгүй/

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 6,362.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-ний хувьд:

- “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Яармагийн авто замд явган хүний нүхэн гарц барих” ХУД Гэрээний дүн: 2,953.8 сая төгрөг, Гүйцэтгэгч Туулын гүүр далай ХХК, /Тендер нээсэн өдрийн байдлаар НД-ын өртэй, зээлийн тодорхойлолт шаардлагад нийцэхгүй, ИТА-ны ажлын туршлага хүрэхгүй, машин механизм нь шаардлагад хүрэхгүй/
- “Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо, 224 дүгээр цэцэрлэгийн орчмын авто гүүр барих ажил” ЧД Гэрээний дүн: 598.4 сая төгрөг, Гүйцэтгэгч Төгс зам ХХК, /Тусгай зөвшөөрөл нь шаардлагад нийцэхгүй, ИТА-ны ажлын туршлага хүрэхгүй, тендерт оролцохоор ирүүлсэн үнийн саналаас өөр дүнгээр гэрээ байгуулсан/
- “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 0.87 км хөлийн голын авто зам, гүүрэн байгууламж” БЗД Гэрээний дүн: 2,810.5 сая төгрөг, Гүйцэтгэгч Чанар хийц ХХК, /Ажил гүйцэтгэхэд ашиглагдах машин, механизмуудын хүчин чадлууд нь тодорхойгүй байхад шалгаруулсан/

Шүүд гэрээ байгуулах журам:

МУЗГ, БНХАУ-ын Экспорт-импорт банк хооронд хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км замын өргөтгөл, шинэчлэл” Гэрээний дүн: 38.2 сая ам.доллар, Гүйцэтгэгч Синохайдро корпрейшн Монголиа ХХК, /Тендерийн баримт бичгийг баталгаажуулаагүй, ажлын төсөв, тоо хэмжээ дутуу байхад тендер зарласан./

Мөн НЗХГ-аас ХАА зохион байгуулсан 94.6 сая ам.долларын төсөвт өртөгтэй 4 ТАХ, НХААГ-аас ХАА зохион байгуулсан 10,597.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний тендерийн баримт материалыг архивлаагүй, аудитын байгууллагаас шаардсан материалыг тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй зэрэг зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1¹⁰, Архивын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3¹¹, 23.2.4¹² дэх заалт, Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 3.7.5.¹³ заалтыг зөрчжээ.

Дүгнэлт: ХАА-г зохион байгуулахдаа холбогдох хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, шаардлагад нийцээгүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

Б.2. Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулсан уу?

2016-2023 онуудад улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө, гадаадын зээлийн хөрөнгөөр шинээр болон өмнөх оноос дамжин хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 151.6 сая ам.долларын гэрээний үнийн дүнтэй 6 ТАХ, 274,256.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ-ний 79.4% буюу 27 ТАХ-нд 3-5 удаа гэрээг сунгасан нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г эхлүүлсэн, ковид-19 цар тахал, хөл хорио тогтоосон зэргээс үүдэлтэй байна. Иймээс санхүүжилтийг 2-5 жилийн хугацаанд хуваан баталж хэрэгжилтийг хангуулжээ.

Мөн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх 27 ТАХ, гадаадын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх 7 ТАХ, нийт 34 ТАХ-нд 2016-2023 онуудад нийт 129.1 сая ам.доллар, 172,872.8 сая төгрөгийг гүйцэтгэлийг үндэслэн олгожээ.

Дүгнэлт: Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г эхлүүлснээс гэрээг олон удаа сунгах, төсвийг жил бүр хуваан батлах шалтгаан болсон байна.

Б.3. Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан эсэх, гэрээ нь хуульд нийцсэн үү?

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7¹⁴ дахь заалтыг үндэслэн НЗХГ-аас 43,748.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 ТАХ, 35.7 сая ам.долларын гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ, БЗД-ийн ЗДТГ-аас 2,810.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ, ХУД-ийн ЗДТГ-аас 1,798.7 төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1 ТАХ-нд тус тус нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулж төсөвт тусгуулжээ.

¹⁰ 15.1.1.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгадагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах;

¹¹ архивын баримтыг эмхлэн цэгцлэх, ангилан төрөлжүүлэх;

¹² архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах;

¹³ "худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийг тухай бүр худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан нийтлэх, цаасан болон цахим баримт, материалыг хуулийн 49 дүгээр зүйлийн дагуу бүрдүүлж архивын нэгж болгон хадгалах, байгууллагын архивт шилжүүлэх;"

¹⁴ Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө.

Дотоод эх үүсвэрээс санхүүжүүлсэн дээрх ТАХ-ний гэрээний үнийн дүн 14.0%-иар буюу 7,864.5 сая төгрөгөөр, гадаад эх үүсвэрээс санхүүжүүлсэн ТАХ-ний гэрээний үнийн дүн 15.8%-иар буюу 6.7 сая ам.доллараар санхүүжилт өссөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5/

Хүснэгт №4. Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулсан ТАХ-үүд

№	Тоо	Гэрээний үнийн дүн	Нэмэлт гэрээний үнийн дүн	/сая төгрөг/	
				Өсөлтийн хувь	
НЗХГ	төгрөг	5	43,748.4	48,957.5	10.6
	ам.доллар	1	35.7	42.4	15.8
БЗД	төгрөг	1	2,810.5	4,310.8	34.8
ХУД	төгрөг	1	1,798.7	2,953.8	39.1

ТАХ-үүд нь 1-8 жил үргэлжилж, 2-с дээш удаа гэрээ сунгасан, 2012 онд магадлал хийгдсэн ажлын зургаар 2022 онд ХАА зарласан, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр ХАА зарлагдаж зураг төсөв магадлалаар ороход төсөвт өртөг өссөн, газар чөлөөлөлт хийгдээгүй зэрэг шалтгаанаар төсөвт өртөг өсжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁵ дэх заалт, Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2022 оны А/12 дугаар тушаалын 5.4.13¹⁶ дахь заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

НЗД-ын 2022.02.01-ний А/132 тоот захирамжаар НЗХГ-т эрх шилжүүлсэн “Чингисийн өргөн чөлөөнөөс Баруун үйлдвэрийн гудамж хүртэлх авто зам, гүүрний барилга” ажлын ХАА зарлан гүйцэтгэгч сонгон шалгаруулж 5,989.6 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гэтэл гэрээ байгуулснаас 9 хоногийн дараа магадлалын дүнг 5,858.9 сая төгрөгөөр баталж гэрээнд өөрчлөлт оруулах ёстой байтал оруулаагүй, 130.7 сая төгрөгөөр илүү хэвээр үлдээсэн зөрчил илэрснийг аудитын явцад залрууллаа.

Дүгнэлт: Төсөвлөлтийн шаардлага хангахгүй ТАХ-г төлөвлөснөөс ТАХ удаашрах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулах үндэслэл болжээ.

Б.4. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу?

2016-2023 онуудад НЗХГ, НХОГ ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, зарим дүүргүүдийн ЗДТГ-уудын гэрээ байгуулсан шинээр болон өмнөх онуудаас шилжин хэрэгжсэн автозамын гүүр, гүүрэн байгууламж, нүхэн гарцын 151.6 сая ам.долларын гэрээний үнийн дүнтэй 6 ТАХ, 274,256.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ буюу нийт 34 ТАХ-г улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө болон гадаадын зээлээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас хэрэгжиж эхэлсэн нийт 32 ТАХ байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 6/

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 32 ТАХ-г бүрэн хамруулж газар дээр нь баримт материалтай нь тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Нийт хэрэгжсэн ТАХ-ний 81.3% буюу 26 ТАХ-нд “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁷-т зааснаар НЗХГ чиг үүргийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

¹⁵ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁶ Авто зам, замын байгууламжийн зураг т с л боловсруулснаас хойш ийн жилд нг м рд гд ж байгаа норм, журмын дагуу шинэчлэх, баталгаажуулах зардлыг холб

¹⁷ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.


Дүрслэл №1.

